

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/47/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б. Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: О.Баярмаа
Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Солид Юнити Аудит ХХК-ийн
захирал: Э.Мөнхтогтох
Утас: 99063227 Цахим хаяг: munkhtogtokh.e@solidunity.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СНАГ-2024/47/НА-СТА-ТӨА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/415
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 97 дугаар тушаалаар Монгол-Францын хамтарсан Бадрах энерги ХХК-ийн хөрөнгө оруулагч Орона майнинг компанитай байгуулах "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төсөл дээр 6 дэд ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Мон-Атом ТӨХХК тайлант онд Бадрах энерги ХХК-ийн хэрэгжүүлж буй Дорноговь аймгийн нутаг дахь Зөөвч-Овоо болон Дулаан-Уулын ураны ордыг газрын доор уусган олборлох аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд зөвлөх үйлчилгээ үзүүлж 155.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Мон-Атом ТӨХХК-ийн үндсэн үйлдвэрлэл эхлээгүй, Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээр хийгдэж байгаа бөгөөд Эрдэнэс Монгол ХХК-тай 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан ЭМГЛ-147/ЗГ-07 дугаар "Зээлийн санхүүжилт олгох гэрээ"-ний дагуу үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн. Тайлант хугацаанд Эрдэнэс Монгол ХХК-иас 1,152.0 сая төгрөгийн санхүүжилт авч, Хөрөнгө оруулалтын гэрээг олон нийтэд таниулан сурталчлах ажлын хүрээнд зохион байгуулах тендерийг хуулийн хугацаанд зарлах, шалгаруулах боломж бүрдээгүйгээс 520.0 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг буцаасан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 стратеги зорилгын 39 зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	17,546,852.10	28,966,814.72
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	116,092,079.10	112,164,621.89
1.1.4	Бусад авлага	100,000.00	1,427,634.06
1.1.6	Бараа материал	15,358,667.99	19,521,577.23
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	4,400,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	149,097,599.19	166,480,647.90
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	52,193,888.82	49,550,837.34
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,670,664,180.00	1,716,678,770.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,722,858,068.82	1,766,229,607.34
1.3.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,871,955,668.01	1,932,710,255.24
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	247,737,683.59	4,059,612.67
2.1.1.2	Цалингийн өглөг	52,460,640.74	52,480,642.49
2.1.1.3	Татварын өр	14,567,225.12	13,475,570.54
2.1.1.4	НДШ-ийн өр	-	177,219.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	314,765,549.45	70,193,044.70
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	9,399,462,909.66	10,690,232,732.57
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	9,399,462,909.66	10,690,232,732.57
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,714,228,459.11	10,760,425,777.27
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	1,675,192,180.00	1,721,206,770.00
2.3.9	Тайлант үеийн ашиг (алдагдал)	(1,314,492,039.67)	(1,031,457,320.93)
2.3.10	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал)	(8,202,972,931.43)	(9,517,464,971.10)
2.3.1	Эздийн өмчийн дүн	(7,842,272,791.10)	(8,827,715,522.03)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,871,955,668.01	1,932,710,255.24

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	31,820,861.67	155,070,445.45
2	Борлуулалтын өртөг	28,871,803.84	116,187,909.24
5	Хүүний орлого	-	307,889.09
8	Бусад орлого		216,065,250.00
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	533,734,534.13	627,892,143.08
11	Санхүүгийн зардал	607,168,677.70	665,607,307.99
12	Бусад зардал	18,884,500.00	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(157,653,385.67)	6,814,444.75
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,314,492,039.67)	(1,031,429,331.02)
19	Орлогын татварын зардал		27,989.91
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,314,492,039.67)	(1,031,457,320.93)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(1,314,492,039.67)	(1,031,457,320.93)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт Дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,675,192,180.00	-	(8,202,972,931.43)	(6,527,780,751.43)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	1,675,192,180.00	-	(8,202,972,931.43)	(6,527,780,751.43)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,314,492,039.67)	(1,314,492,039.67)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,675,192,180.00	-	(9,517,464,971.10)	(7,842,272,791.10)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	1,675,192,180.00	-	(9,517,464,971.10)	(7,842,272,791.10)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(1,031,457,320.93)	(1,031,457,320.93)
Өмчид гарсан өөрчлөлт	46,014,590.00	-	-	46,014,590.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,721,206,770.00	-	(10,548,922,292.03)	(8,827,715,522.03)

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	35,028,692.36	171,124,690.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	31,820,861.67	155,070,445.45
1.1.4	Буцаан авсан албан татвар	3,182,086.17	15,507,044.55
1.1.5	Бусад мөнгөн орлого	25,744.52	547,200.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	553,761,682.21	696,128,372.50
1.2.1	Ажилчдад төлсөн	319,270,756.50	290,239,406.10
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	105,551,809.41	93,161,895.90
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,622,050.38	16,097,815.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	10,182,726.23	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,342,991.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	31,636,461.77	36,222,505.99
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	72,154,886.92	260,406,749.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(518,732,989.85)	(525,003,682.50)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	29,171,803.84	17,497,295.20
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	29,171,803.84	17,217,396.02
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	279,899.18
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	45,742,403.84	113,055,475.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	10,357,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	45,742,403.84	102,698,475.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,570,600.00)	(95,558,179.80)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	560,768,904.58	1,152,042,674.92
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	560,768,904.58	1,152,042,674.92
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,080,515.50	520,060,850.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	23,080,515.50	520,000,000.00
3.2.1	Бусад мөнгөн зарлага	-	60,850.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	537,688,389.08	631,981,824.92
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,384,799.23	11,419,962.62
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,162,052.87	17,546,852.10
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,546,852.10	28,966,814.72

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
1	Орлого			
1.1	Ажил үйлчилгээ борлуулсны орлого	-	155,070,445.45	
1.2	Борлуулсан ажил үйлчилгээний өртөг		116,187,909.24	
1.3	Цэвэр борлуулалт		38,882,536.21	
1.4	Хүүгийн орлого		307,899.09	
1.5	Ханшийн зөрүүгийн олз		6,814,444.74	
1.6	Бусад орлого		216,065,250.00	
2	Үндсэн үйл ажиллагааны зардал			
2.1	Цалингийн зардал	413,286,000.0	381,017,641.85	92.2%
2.2	НДШ-ийн зардал	56,280,750.00	46,297,460.90	82.3%
2.3	Ажилтнуудын хоол, унааны хөнгөлөлт	36,960,000.00	-	0.0%
2.4	Бичиг хэргийн зардал	7,533,200.00	5,739,453.49	76.2%
2.5	Албан томилолт	40,000,000.00	40,443,789.00	101.1%
2.6	Шуудан, харилцаа холбоо, интернэт	6,360,000.00	3,489,506.18	54.9%
2.7	Хангамжийн материалын зардал	5,471,000.00	6,328,285.82	115.7%
2.8	Зар, сурталчилгааны зардал	770,000,000.00	72,790,908.36	9.5%
2.9	Түрээсийн зардал	6,000,000.00	2,290,200.00	38.2%
2.10	Нийгмийн арга хэмжээ	2,000,000.00	2,284,000.00	114.2%
2.11	Зөвлөх үйлчилгээ	4,500,000.00	-	0.0%
2.12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	330,000,000.00	54,328,500.00	16.5%
2.13	Зээлийн хүүгийн зардал	674,260,394.00	665,607,307.99	98.7%
2.14	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	34,166,037.00	12,853,051.48	37.6%
2.15	Албан татвар төлбөр хураамж		57,335.91	
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,386,817,381.00	1,293,527,440.98	54.2%
	ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	(2,386,817,381.00)	(1,031,457,320.94)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 216.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 216.1 сая төгрөгийн алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мон-Зим интернэйшнл ХХК-тай холбоотой өглөгийг холбогдох шийдвэр, тушаалын дагуу бүртгэлээс хасаагүй.	1	216,065.3	1	216,065.3			1	216,065.3				
Дүн	1	216,065.3	1	216,065.3			1	216,065.3				

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.5 сая төгрөгийн зөвлөмж өгсөн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй.	1	-					1	-				
Компанийн бүртгэлд тусгасан НӨАТ-ын худалдан авалтын дүн нь татварын цахим	1	371.7					1	371.7				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

системийн мэдээний дүнгээс зөрүүтэй.											
Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан.	1	177.2				1	177.2				
Дүн	3	548.9				3	548.9				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 382.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 382.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны хуулийн дагуу 3 мэдээллийг ил тод байршуулаагүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	329,876.6			1	329,876.6		
Дүн	1	329,876.6			1	329,876.6		
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Компанийн өөрийн хөрөнгөд (төрийн өмчид) гарсан өөрчлөлтийг компанийн дүрэм болон гэрчилгээнд тусгаж хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлээгүй.	1	-			1	-		
2022 оны санхүүгийн тайлангийн аудитын үр дүнгээр өгсөн 41 хүнтэй холбоотой 52.5 сая төгрөгийн цалингийн өглөгт холбогдох арга хэмжээ авах, алдаа зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	1	52,460.6			1	52,460.6		
Дүн	2	52,460.6			2	52,460.6		

Мон-Атом ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой

Компанийн албан хэрэгцээнд ашиглаж буй “Тоёото камри” маркийн УБО 58-39 улсын дугаар бүхий тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цэнхэр дугаараар солиогүй.	1	-						
Дүн	1	-						
Нийт дүн	4	382,337.2			4	382,337.2		